



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2020 оны 04 сарын 10 өдөр

Дугаар А/231


Улаанбаатар хот

Шинэ коронавируст халдвар(COVID-2019)-ын  
үед нэн шаардлагатай эм болон эмийн түүхий эдэд  
импортын лиценз олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5 дах хэсэг, "Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх хугацааг сунгах тухай" Засгийн газрын 2020 оны 102 дугаар тогтоолын 1 дүгээр заалт, Хүний эмийн зөвлөлийн 2020 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ай Ви Ко Хэлт Кэйр ХХК-д импортын лиценз олгох эмийг нэгдүгээр, Ай Ви Ко Интернэшнл ХХК-д импортын лиценз олгох эмийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Бодлогоор бүртгэх эмийн бүртгэлийн үйл ажиллагааг эрчимжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/-д даалгасугай.
3. Импортлосон эмийн чанар, аюулгүй байдлыг бүрэн хариуцаж, импортлох үйл ажиллагааг шуурхай зохион байгуулж ажиллах, эмийн сан, эрүүл мэндийн байгууллагыг эмээр тасралтгүй, жигд хангаж, зохиомол хомсдол, үнийн хөөрөгдөл үүсгэхгүй байхыг эм ханган нийлүүлэх байгууллагуудын дарга, захирал нарт үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эм, үйлдвэрлэл, технологийн газар /Н.Гэрэлт-Од/-т даалгасугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

Эрүүл мэндийн сайдын 2020 оны 04  
дугаар сарын 10-ны өдрийн 1231  
дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



АЙ ВИ КО ХЭЛТ КЭЙР ХХК-Д  
ИМПОРТЫН ЛИЦЕНЗ ОЛГОХ ЭМИЙН ЖАГСААЛТ

Д/Д	Эмийн нэр	Тун хэмжээ	Эмийн хэлбэр	Тоо хэмжээ	Үйлдвэрлэгчийн нэр
1	Поспенем /Имипенем/	1 гр	Тарилгын уусмал бэлтгэх нунтаг	5,000 флакон	"JW Pharmaceutical", БНСУ

Эрүүл мэндийн сайдын 2020 оны 04...  
дугаар сарын 10...-ны өдрийн ...  
дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



АЙ ВИ КО ИНТЕРНЭШНЛ ХХК-Д ИМПОРТЫН ЛИЦЕНЗ ОЛГОХ  
ЭМИЙН ТҮҮХИЙ ЭДИЙН ЖАГСААЛТ

Д/Д	Эмийн нэр	Хэмжих нэгж	Хэлбэр	Тоо хэмжээ	Үйлдвэрлэгчийн нэр
1	Тетракайн гидрохлорид	кг	Нунтаг	5кг	"Acofarma Distribution S.A", Итали
2	Натрийн лактат	кг	Өтгөрүүлсэн шингэн	800 кг	"Luoyang Longmen Pharmaceutical" Co.,Ltd, БНХАУ